

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-11

-
- 1. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, хамт өргөн
мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулсан хууль,
тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын
Ерөнхийлөгчийн хориг** 3-11

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 11 дүгээр сарын 22-ны өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 23 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, Б.Батцэцэг, Г.Дамдинням;
Чөлөөтэй: Б.Чойжилсүрэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа, П.Мөнхтулга.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар, мөн газрын Хуулийн бодлогын газрын дарга Ж.Мөнхболд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх Б.Даваадалай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн дарга М.Үнэнбат, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Я.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, Ж.Батжаргал, Н.Алтанхуяг, Ж.Баясгалан, Г.Ганбаатар, З.Мэндсайхан, Б.Түвшин, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

Ц.Даваасүрэн: Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 3
Бүгд: 19
84.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Д.Батбаяр нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 94.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 30 минут үргэлжилж, 25 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 76.0 хувийн ирцтэйгээр 12 цаг 53 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр, Баасан гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим,
12 цаг 23 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Төсвийн байнгын хорооны хуралд ирвэл зохих 25 гишүүнээс 16 гишүүн ирж, 64 хувийн ирцтэй байгаа учраас хуралдаанаа эхэлье. Би ирсэн гишүүдээ танилцуулаадахъя.

Миний бие, Н.Алтанхуяг гишүүн, Т.Аубакир гишүүн, Д.Батбаяр гишүүн, Р.Батболд гишүүн, Ж.Батжаргал гишүүн, Ж.Баясгалан гишүүн, Ж.Ганбаатар гишүүн, Г.Ганбаатар гишүүн, П.Ганзориг гишүүн, Х.Ганхуяг гишүүн, Б.Мөнхсоёл гишүүн, З.Мэндсайхан, Д.Пүрэвдаваа гишүүн, Б.Түвшин гишүүн, Да.Цогтбаатар гишүүн нар өнөөдрийн хуралд бүртгүүлсэн байна. Ингээд ирц бүрдсэн тул Төсвийн байнгын хорооны 2024 оны 11 сарын 22-ны хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. 1 асуудал байгаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль, тогтоомжид бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуулттай холбогдуулан саналтай гишүүн байна уу. Алга байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль, тогтоомжид бүхэлд нь хориг тавьсан асуудлыг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг би та бүхэнд танилцуулъя. Гомбожавын Занданшатар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Батсуурийн Даваадалай Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх, Жаргалсайханы Мөнхболд Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга гэсэн ийм 3 хүн оролцож байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар танилцуулна. 6 номерын микрофоныг өгье.

Г.Занданшатар: Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг үндэслэн бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон түүнтэй хамт өргөн мэдүүлсэн, холбогдуулан боловсруулж баталсан хуулийн төслүүдэд бүхэлд нь хориг тавьсан.

Хориг тавьсан үндэслэл бол 1 дүгээрт гадаад зах зээлийн төлөв байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлийг харгалзан гадаад валютын улсын нөөц, төсвийн хуримтлалыг нэмэгдүүлэх, өрийг бууруулах зэрэг суурь зарчмуудыг анхаарч мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлж алдагдалгүй төсөв батлах нь зүйтэй байна гэж үзсэн.

Олон улсын геополитик гео стратегийн нөхцөл байдал зөрчилдөөнөөс шалтгаалж гадаад эдийн засгийн төлөв байдал бол урьдчилан таамаглах боломжгүйгээр хувьсан өөрчлөгдөж байна. Үүнээс шалтгаалаад түүхий эдийн үнэ ч гэсэн түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнэ ханш өндөр хэлбэлзэлтэй байна. Тэгэхээр энэхүү эгзэгтэй цаг үед мөчлөг сөрсөн эдийн засгийн бодлого хэрэгжүүлж, үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй, хөгжилд хөтөлсөн төсөв төлөвлөж батлах нь нийт иргэн, улсын ашиг сонирхолд бүрнээ нийцнэ гэж үзэж байгаа юм.

Энэ нь эдийн засгийн болзошгүй хүндрэл бэрхшээлийг хохирол багатай даван туулах, нөөц боломж, хуримтлалыг нэмэгдүүлэх, үнэ ханшийн өсөлтийг хязгаарлах, урьдчилан сэргийлэх, эдийн засгийн тогтвортой байдал ард иргэд, аж ахуйн нэгж, татвар төлөгчдийн хэвийн үйл ажиллагааг хангах баталгаа болно гэж үзсэн.

Эдийн засгийн тогтвортой байдал өсөлтийг хангах нь хөгжлийн бодлого, тэргүүлэх зорилт, төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж, улсын аюулгүй байдал, тогтвортой хөгжил, ард иргэдийн амьдралын чанарыг сайжруулах үндэс суурь болохыг хүмүүс санах учиртай.

Монгол УИХ 2025 оны улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д заасан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах. Мөн хуулийн 6.5.1-д заасан төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх, мөн Төсвийн тогтвортой байдлын тухай байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т заасан төсвийн бодлого, стратегийн зорилт нь макро эдийн засгийн болон татварын тогтвортой орчныг бүрдүүлэх, инфляцыг хязгаарласан байхад чиглэсэн байх, 5.1.6-д төсвийн хөрөнгийн хуваарилалт, байршуулалт, хэрэглээ нь эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой байх гэсэн заалтуудыг бүрэн хангаагүй бөгөөд энэ нь хууль дээдлэх Үндсэн хуулийн зарчимд нийцэхгүй байна гэж үзсэн. Үүний зэрэгцээ Монгол Улсын Их Хурлаар 3 сарын өмнө баталсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсвийн урсгал зардлын тэлэлтийг хязгаарлана гэсэн зорилтоо бодитой хэрэгжүүлж ажиллахыг төрийн тэргүүн сануулж байна.

Мөн ард иргэд, баялаг бүтээгчид, татвар төлөгчид, мэргэжлийн байгууллагуудын зүгээс төсвийн сахилга батыг чангатгах, үр ашигтай, хэмнэлттэй байх нийтлэг зарчимд нийцүүлэн төсвийн зардлыг бууруулах чиг үүргийн давхардлыг арилгах, улс төрийн намууд, эвслүүд сонгуулийн амлалтаа биелүүлэх зэрэг санал шүүмжлэлийг илэрхийлж байгаа нь зүй ёсны шаардлага хэмээн үзэж байна.

2 дугаарт Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль тогтоомжууд нь Монгол Улсын үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх нь

төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэсэн заалтыг зөрчих нөхцөлийг бий болгож байна гэж үзсэн.

Улсын Их Хурал 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 41 дүгээр тогтоолыг баталсан. Энэ тогтоолоор Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль нь Төсвийн болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан зарчмуудыг бүрэн хангаагүй, төрийн мөнгөний бодлогод нийцээгүй, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж чадаагүй болохоо хүлээн зөвшөөрч, батлагдсан төсвийг тодотгож, дахин засаж сайжруулах шаардлагатай гэсэн агуулгыг илэрхийлсэн байна. Энэ тогтоол.

Мөн Монгол Улсын төсвийн тухай хуулийн 34.1 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт Засгийн газар дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж заасан. Гэтэл Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль хүчин төгөлдөр болж, дагаж мөрдөж эхлээгүй, Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасан нөхцөл тохиолдол бүрдэж үүсээгүй байхад Улсын Их Хурал төсөвт тодотгол хийхээр тогтоол баталж, чиглэл болгож байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэх заалтыг зөрчиж, хууль зөрчих нөхцөлийг бий болгосон байна гэж үзэж байна.

Иймд дээр дурдсан үндэслэлээр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулж боловсруулсан, баталсан, улмаар хууль тогтоомжид бүхэлд нь тавьсан хоригийг холбогдох хуулийн дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Ц.Даваасүрэн: Занданшатар даргад баярлалаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригтой холбогдуулан асуух асуулттай гишүүдийн нэрсийг авъя. Байхгүй байна. Ерөнхийлөгчийн хоригтой холбогдуулж үг хэлэх гишүүн байна уу. Батжаргал, Мэндсайхан, Баясгалан, Ганбаатар. Ганбаатар гишүүнээр тасаллаа. Алтанхуяг гишүүн үгээ хэлье. Биш ээ, энэ дараалал нь өөрчлөгдчихлөө. Нөгөө ирснээрээ юм байх даа ирчихсэн ирсэн. Да.Цогтбаатар үг хэлье.

Да.Цогтбаатар: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Улсын төсөв 2025 оны Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд хориг тавьсан энэ хоригийг бол их талархан хүлээж авч байгаа. Учир нь энэ төсвийг алдагдалгүй батлах боломжтой байна. Урсгал зардал дээрээсээ нэлээд олон боломжуудыг гаргаад, 126 гишүүнтэй парламент анхныхаа алдагдалгүй төсвийг батлаад, Монгол Улс Олон улсад бас эерэг дохио өгөөд, зээлжих зэрэглэлээ сайжруулаад, орж ирэх эх үүсвэрийн зардлыг бууруулаад явах боломжтой байна гэж өмнө нь бас нэлээн хэдэн удаа хэлсэн. Тэгээд Улсын Их Хурал, Засгийн газар яг энэ чигээр нь батлаад явуулсан. Ер нь бол бид нар ямар ч хэмнэлт хийж чадаагүй. Тэгээд бид нар эндээс тодорхой хэмжээний хэмнэлтийг хийж чадах юм бол алдагдалгүй, ядахдаа алдагдалгүй төсөв баталчих юм бол өнөөдөр үнэ ханшийн уналт гэж яриад байгаа, ялангуяа энэ дотор бол хамгийн ихээр нэмэгдээд байгаа нь Монгол төгрөгийн үнэ өөрөө маш ихээр унаж байгаа. Тэгээд энэ Монгол төгрөгийн ханшийн уналтыг бага ч болтугай энэ дээр нэг нэмэр олж авч үлдэх тус дэм болох байх.

Дээрээс нь энд бол Ерөнхийлөгчийн хориг дээр бичсэн байгаа хуримтлалыг бас нэмэгдүүлэх гээд. Энэ хуримтлалыг нэмэгдүүлэх, үнийг тогтоох гэдэг дээр бол миний хувьд нэлээн ач холбогдол өгч байгаа учраас энийг бол маш зөв зүйтэй хориг болсон гэж талархаж хүлээж авч байгаа. Тэгээд Төсвийн байнгын хороо үргэлжлүүлээд Улсын Их Хурлыг бас энэ хоригийг хүлээж авна байх гэж найдаж байна. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр Монгол Улсын Ерөнхийлөгч өөрт олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын 2025 оны төсөвт бүхэлд нь хориг тавьсан байна. Тэгэхээр Улсын Их Хурал энэхүү хоригийг хүлээж авах нь зүйтэй гэж үзэж байгаа. Нэгэнт хориг хүлээн авч байгаа бол Төсвийн тухай хууль үйлчлэл нь үндсэндээ зогсож байгаа юм. Тийм учраас хууль дээдлэх зарчмаа баримталж, Төсвийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд тодорхой өөрчлөлт оруулж, орон нутгууд төсөв боловсруулж өргөн мэдүүлдэг, баталдаг цаглаврыг энэ жилийн хувьд харах ёстой бид. Тэгж байж нийтээрээ энэ хууль дээдлэх зарчмаа баримталж, эрх зүйн мухардалд орохоос урьдчилж гарах ёстой. Тийм учраас энэ асуудлыг би Төсвийн байнгын хороог анхааралдаа авч, тэр төсвийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг боловсруулах ёстой байх гэж ингэж ойлгож байна.

2 дугаарт мэдээж Улсын Их Хурал хориг хүлээн авсантай холбогдуулаад төсөл өргөн баригчтай тодорхой төсвийн зардал зүйлүүд дээр нарийсгаж дүн шинжилгээ хийх асуудлууд байгаа. Тэрийг бол мэдээж Их Хурлаас томилогдсон ажлын хэсгийн түвшиндээ нэлээн нарийсгаж үзэж, тэндээс гарч ирсэн санал, дүгнэлтүүд дээрээ тулгуурлаж, илүү сайжруулж, тэнцлээ сайжруулж, ингэж л төсвөө батална гэж би бол ингэж л ойлгож байгаа. Тийм учраас энэ нь бол Их Хурлын хэлэлцүүлгийн явцад тодорхой болох байх. Ийм саналтай байна.

Ц.Даваасүрэн: Алтанхуяг гишүүн.

Н.Алтанхуяг: Ерөнхийлөгч энэ төсөв дээр, ирэх оны төсөв дээр хориг тавьсан нь их зөв зүйтэй болжээ. Энэ зөвхөн Ерөнхийлөгчийн ч зөв биш. Одоо энэ миний өөдөөс хараад сууж байгаа энэ Тэмүүлэн, Түвшин, Энхтүвшин, Баярмаа гээд энэ гишүүдийн бас зөв байсан гэдгийг нотолж байгаа юм л даа. Энэ Улсын Их Хурал өчнөөн олон гишүүд ийм санал, санаачилга гаргаад байхад өөдөөс нь толгойд нь хурамш боож байгаа юм шиг худлаа молиго үмхүүлээд, хойноос нь Улсын Их Хурлын тогтоол гаргаж, хууль зөрчиж батлагдаагүй төсөвтөө тодотгол хийх тухай ийм солиотой Их Хурлын тогтоол гаргасан. Энэ Их Хурлын хийсэн ажил биш шүү дээ. Энэ нэг хэдэн дарга нарын л хийсэн ажил шүү дээ. Тэгэхээр энэ зөвдөх шинж рүүгээ явж байна уу гэж би харж байна. Харин энийг нь хэдүүлээ зөв зүйтэй ашиглаад, зөв юм хиймээр байна. Одоо тэгэхдээ Их хурал нэг яламд унана шүү дээ. Сая Их Хурал дээр Даваасүрэн дарга та мэдэж байгаа. Би гараа өргөж байгаад ажлын хэсэгт ороод ажиллаад л сүрхий юм хийчихье гээд л овоо төсөв янзалъя гэсэн явж байгаад л тэгээд л Ардын намын бүлэг хуралдаад л тэгээд л бандан тас болоод л ямар ч өөрчлөлтгүйгээр батлагдсан шүү дээ. Тэгэхээр танай намын бүлэг энийг өөрчилъе гэсэн хүсэл зорилготой байгаа юм байгаа биз дээ. Байхгүй бол тэгээд л наадах чинь дахиад л бантан болно. Би бол ажлын хэсэгт орохгүй. Тэмүүлэн. Одоо ингэж тийм тоглоомын хүүхэлдэй болохоо больё.

Дахиад би нэг юм хэлчихье Даваасүрэн дарга аа. Энэ Засгийн газрын оролцоотойгоор энэ төсвөө жаахан янзлахгүй бол Их Хурал хэрэгт орно. Дараа нь тэр хаа, гуяар нь салгаад Их Хурал хасаад хаячихсан. Ер нь тийм зөрчилт байдал руу хийх ийм юм энэ Жавхлангийн үеэс яваад байгаа учраас би ямар санал хэлээд байгаа вэ гэхээр Засгийн газар угаасаа болдог бол юмаа аваад засах ёстой. Хуулиараа болдоггүй юм бол Засгийн газрыг оролцуулж байгаад, хаа гуяыг нь салгачихгүйгээр, хуруу хумсыг нь салгачихгүйгээр янзлах ёстой. Урсгал зардлыг бол хангалттай танаж болохоор байгаа шүү дээ. Хууль зөрчөөд зөвхөн нийслэл дээр гэхэд 2 мянга орчим ухуулагч ажиллаж байгаа шүү дээ. Хэсгийн ахлагч нэртэй. Тэрний цалин цавыг нь бодох юм бол хэд вэ, энэ чинь 100 тэрбум төгрөг шүү дээ. 100 тэрбум төгрөгөөр хүн цалинжуулж байгаа шүү дээ. Гэх мэтчилэн хүсэл зоригоо нэг илэрхийлээд Засаг, Их Хурал, Ерөнхийлөгч гэж ингэж талцахгүйгээр Монголчуудын ирэх оны амьдрал ахуй, аж ахуйн нэгжүүдийнхээ үйл ажиллагаанд нь нэмэр болох байдлаар энийгээ өөрчилж янзлаач ээ гэж би хэлж байна. Би ажлын хэсэгт орохгүй ээ.

Ц.Даваасүрэн: Тийм тийм. Алтанхуяг гишүүний хэлж байгаа үнэн. 2010 онд бол ерөнхийд нь 10 хувиар тарьж байна гэж байгаад эрүүл мэндийн салбарынхан нөгөө ариутгалын бодисоо хэмнээд, тэгээд 12 хүүхдийн амины хэрэгт Ламбаа гишүүн орчих дөхөж байсан шүү дээ Эрүүл мэндийн сайд байхдаа. Тийм учраас бид нар бас Засгийн газрын бүх байгууллагуудтай нэлээн сайн ингэж ажиллахгүй бол зүгээр л хөнгөн хийсвэрээр бас хандаж болохгүй. Баясгалан гишүүн.

Ж.Баясгалан: Ерөнхийлөгчийн оруулж ирсэн хоригийг бол дэмжиж байгаа бүрэн дүүрэн. Тэгээд энэ дундаас бол төсвийн хөрөнгийн хуваарилалт, байршуулалт, хэрэглээ нь эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой байх гэсэн заалтуудыг хангаагүй байна гэсэн энэ үндэслэлтэй бол 100 хувь санал нийлж байгаа. Тэгээд бид нар бол яг сая төсөв хэлэлцэх үеэр ч тэр Төсвийн байнгын хороо, бүх л Байнгын хороо дээр яригдсан асуудлууд бол нөгөө төрийн өмчит компаниуд байгаа маш олон. Ерөөсөө ямар ч үр дүнгүй ажилладаг, ямар ч үр ашиггүй ажилладаг. 4 компани нь үр ашигтай ажиллаад, 2 компанийнх нь үр ашиг нь 4,6 их наяд төгрөг болж байгаа. Тэгэхэд үлдсэн 100 компани нь ерөөсөө үр ашиггүй. Тэр дундаа 70 гаруй хувь нь бол ерөөсөө дан алдагдалтай ажилласан. Тэгэхээр энийг өөрчлөх боломж байна.

2 дугаарт гэвэл одоо дахиад л хэлье. Өнөөдөр өдөр болгон 14 хүн хорт хавдраар хорвоог орхиж байгаа. Монгол Улсад шүү дээ. Тэгэхэд энэ утаанаас болоод дахиад л нэмэгдэж байгаа юм. Тэгэхээр энэ асуудлыг зогсоох боломж, Монгол иргэдийнхээ амь насыг аврах боломж дахиад гараад ирж байна. Хавдрын эмнэлгээ энэ төсөвтөө оруулчих боломж бид нарт гарч ирж байна. Бэлэн байгаа. Төрд хураагдчихсан байгаа, Хөгжлийн банканд хураагдчихсан байгаа тэр эмнэлгийн зориулалтаар ашиглаж байгаа тэр барилгыг дахиад яг хавдрынхаа эмнэлгийн чиглэлээр ашиглахад болохгүй зүйл байхгүй гэдгийг бол Эрүүл мэндийн яам бол өөрсдөө эмч эмнэлгийн ажилчид бүгдээрээ хэлсэн. Тэгэхээр энэ яг саяын нийгмийн ач холбогдолтой байх гэдэг дээр бол яалт ч үгүй энэ хавдрын эмнэлэг орж байгаа. Тийм болохоор бид нар энэ төсөв дээрээ үнэхээр өөрчлөлт хийх энэ боломж гарсан дээр нь бас Төсвийн байнгын хорооныхоо гишүүдэд хандаад хэлэхэд энэ хавдрын эмнэлгийн асуудал дээр бас анхаарлаа хандуулаад өгөөрэй. Энэ бол бид нарыг тойрохгүй, өдөр болгон бид нарт тохиолдож байгаа асуудал шүү.

Тэгээд хоригийг бол одоо хүлээн зөвшөөрч байна. Хоригийг бол дэмжиж байна. Энэ дээр нь харин Төсвийн байнгын хороонд хэрвээ ажлын хэсэгт Алтанхуяг дарга гарч байгаа бол хэрвээ болбол би өөрөө бас орж ажиллах сонирхлоо илэрхийлж байна шүү. Хэрвээ болбол би ажлын хэсэгт оръё.

Ц.Даваасүрэн: Г.Ганбаатар гишүүн.

Г.Ганбаатар: Ерөнхийлөгчийн хоригийг мэдээж хүлээж авах нь зөв өө. Угаасаа энэ шинэ парламент, шинэ Засгийн газар эхнийхээ хариуцлагагүй байсныхаа сануулгыг авч байх шиг байна. Ер нь төсвийн 2 дугаар хэлэлцүүлэг болж байх үед л урсгал зардал дэндүү их байна шүү дээ. Тэгээд дээрээс нь энэ хөрөнгө оруулалтуудаа эрэмбэлье, шаардлагагүй, нэн шаардлагагүй хөрөнгө оруулалтууд маш маш их байна шүү дээ гээд гишүүд яриад л байсан. Тоогоогүй шүү дээ Сангийн яам. Тэр битгий хэл 2 дугаар хэлэлцүүлгийн өмнө бас хэвлэлийн бага хурал ч хийж л байсан.

Дээрээс нь бид бас өөрсдөө муу ажилласан шүү дээ төсвийн ажлын хэсэг. Үүнийгээ бас хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Тэгээд одоо яах вэ, тэгээд урсгал зардал, шаардлагагүй хөрөнгө оруулалтуудаа танана биз. Үүнтэй холбоотой зүгээр ингээд юу хэлэхэд 2 зүйл. Энэ өнгөрсөн жил чинь бас Улсын Их Хурлын сонгуулийн өмнө 4 сарын 1 гээд баахан цалин, тэтгэвэр, тэтгэмж үүний чинь зардал нийтдээ хагас их наяд болсон юм байна шүү дээ. Би Булгантуяа сайдын 2024 оны 3 сарын 20-ны өдөр хийж байсан тэр мэдээллийг татаж аваад үзээд байж байлаа. Энэ чинь үндсэндээ бараг хагас их наяд төгрөг байна.

Дараагийн асуудал нь аливаа хууль батлахдаа бид нар ард нь гарах санхүүгийн эх үүсвэрийг нь тооцохгүй бол бас энэ хуультай чинь холбогдуулаад 400-аад тэрбум төгрөгийн зардал гарчихсан байна шүү дээ. Цэрэг, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Шүүх шинжилгээний албаны тухай хууль гээд. Тэгээд үүнтэй чинь холбоотой бас нэмэгдсэн юмнууд их байгаа юм байна. Энэ мэтийгээ цаашдаа бодож байхгүй бол энэ мэтчилэнээр явж явж тэгээд парламентынхаа нэр хүндэд халгаатай л зүйл хийгээд байна шүү дээ бид нар. Ийм л санал байна.

Ц.Даваасүрэн: Мэндсайхан гишүүн.

3.Мэндсайхан: Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг талархан хүлээж авч байна. Ер нь төсвийн бодлого бол макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, инфляцыг хязгаарлах энэ бодол зорилтын хүрээнд төлөвлөгдөх ёстой. Энэ жилийн Засгийн газраас өргөн баригдсан төсөв бол нэлээн урсгал зардлын тэлэлттэй. Тэгээд бид нар одоо 14 том мега төсөл хэрэгжүүлнэ гэж импортыг дэмжих энэ том эдийн засгийн том төслүүдийг хөдөлгөхөөр төлөвлөчихсөн, энийгээ дагаад урсгал зардлуудаа нэмээд төлөвлөчихсөн ийм төсөв болсон. Тэгэхээр энэ төсөвт хориг тавьсны үр дүн бол хэрвээ энэ төсөв маань ийм том тэлэлттэй хэвээрээ явсан бол Монгол банк бодлогын хүүгээ өсгөхөөс өөр замгүй болно. Дагаад арилжааны банкнууд зээлийн хүүгээ өсгөнө. Энэ хувийн хэвшил, бизнесийнхэн маань ямар нэгэн зээл авах санхүүгийн орон зай, бизнесийн орон зайгүй болж байсан юм. Энэ асуудлыг хэлээд байсан. Тэгээд хүч түрээд явчихсан. Тэгэхээр ирэх жил энэ хувийн хэвшлүүдээ дэмжих, ялангуяа инфляцын талд нь, мөнгөний бодлого талдаа илүү анхаарахгүй бол болохгүй нь гэдгийг хэлэлцүүлгийн явцад бас гишүүд маань анхаарах байх. Их Хурлын гишүүд

маань. Тэгээд энэ хоригийг бол дэмжиж байна. Гол нь бид макро орчныхоо эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, энэ инфляцыг хязгаарлах чиглэлээ л баримтлах ёстой шүү. Яагаад гэхээр ирэх онд хамгийн том төслүүдээ бид хөдөлгөнө гэдгээ төлөвлөөд, Засгийн газар бодлого болгоод явж байгаа учраас гэдгийг хэлье.

Ц.Даваасүрэн: Түвшин гишүүн.

Б.Түвшин: Ерөнхийлөгчийн хоригийг бол талархан хүлээж авч байгаа. Ер нь бид нар энэ төсвийнхөө суурь үзүүлэлтүүдийг зарчмуудаа дахиж харахгүй бол шинэ 116 гишүүн батлагдсаныхаа дараахан төсвийн тодотголоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг өөрчилсөн. Ингэснээрээ төсвийн урсгал зардал 2023 онд 17 их наяд байсан бол 2024 онд 21 их наяд, тодотголоор 24 их наяд, одоо 2025 онд 26 их наяд болох зэргээр ингэж огцом өсөлт орж ирсэн. Энэ бол бас нөгөө талдаа бид нар тодотголоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагууд тэр дотроо 6.1, 6.1.2, 6.1.3 буюу энэ өсөлтийг төсвийн зардлын өсөлтийг хязгаарласан заалтуудыг авч хаясан. Тэгэхээр уг үндэс нь ерөөсөө тэнд байгаад байгаа юм. Цаашдаа бид нар энэ төсвийн зардлын өсөлтийг хязгаарлах тэр заалтуудаа буцааж сэргээхгүй бол энэ улсын төсвийн зардал өсдөг байдал бол цаашдаа буурахгүй. Цааш цаашдаа л ийм л байдлаараа орж ирэх хандлагатай байгаад байгаа юм. Энэ урсгал зардал огцом өсөж байгаа энэ шалтгаанууд мэдээж тайлбаруудтай. Төрөл бүрийн л тайлбаруудтай байгаа. Гэхдээ энэ цаашаа өсөөд явах юм бол манай нийт төсвийн орлогын 77 хувь болж байгаа. Хөрөнгө оруулалт гэж нэрлээд байгаа нь 10 их наяд. Үүний 5 их наядыг нь бол бараг зээлээр шахуу санхүүжүүлэх гэж байгаа. Тэгэхээр цаашдаа бид нар хөрөнгө оруулалт ч хийж чадахгүй хэмжээний төсвөө урсгал зардалдаа зарцуулдаг ийм байдал руу явах гэж байгаа. Ер нь бол бол олон зардлын нэр төрлүүдээр хасна гэдэг логикийн хувьд бол бас тийм таатай зүйл биш. Гэхдээ энэ өндөр өсөлтийн хувь, эндээс гарах үр дүнгүүдийг үндэс сууриар нь нэг сайн ярилцаж, дэлгэрэнгүй гаргаж, ядаж төсвийн алдагдалгүй байх хэмжээний төсвийнхөө тэнцлийг сайжруулахгүй бол бид нар ирэх ирэх жилүүдэд ч гэсэн хэцүү байдалд орох нь. Энэ бол зүгээр нэг зардал хасах гээд байгаа тухай биш. Энэ өөрөө бас Сангийн яамныхан ч гэсэн тус болж байгаа. Бид нар батлагдаад удаагүй байж байхад л олон улсын зах зээл дээр байж байгаа манай гол хамааралтай болох уул уурхайн бүтээгдэхүүний өсөлтүүд дандаа үнэ нь буурч эхэлж байна. Олон улсын улс төрийн байдал ч гэсэн тогтворгүй болж байна. Тэгэхээр энэ Ерөнхийлөгчийн хоригийг ашиглаж бид нар бас дараа дараагийнхаа тогтвортой байдлаа хангах, төсвөө зөв болгох, цаашдаа ер нь бол төсвөө алдагдалгүй баталж байх энэ горим руу шилжих суурь тавигдана гэж бодож байгаа. Тэгэхээр энэ хоригийг бол бид нар хүлээж авч, илүү үр ашигтай болгох хэрэгтэй гэж ингэж бодож байна.

Ц.Даваасүрэн: Би бас хоригтой холбогдуулаад саналаа хэлье. Тэгээд ер нь бол төсөв хэтэрхий өссөн нь бол үнэн. Тийм учраас Ерөнхийлөгчийн хоригор бид нар бас тодорхой хэмжээгээр хасах нь нэг талаасаа зөв. Нөгөө талаасаа хамгийн том ач холбогдол бол цаашдаа өсөхгүй. Би яагаад тэгж хэлж байна вэ гэвэл 2, 3 жилийн өмнөөс би төсвийн өсөлттэй холбогдуулж үг хэлж байсан юм. Энэ төсөв чинь 11 оны төсөв чинь 2 дахин өсчихлөө. Тэмүүлэн тэр үед Байнгын хорооны дарга байсан санагдаж байна. 2 дахин өсчихлөө. Дан ганц нүүрснээс хамаарч байна. Нүүрсний үнэ унавал яах юм бэ. Сая төсөв орж ирэхэд ч би хэлсэн. Таг л байцгаасан. Нэгэнт төсөв ингээд өсчихсөн хойно танах маш хэцүү. Одоо би энэ гишүүдийг өөрсдөө оролцоод хасах хэрэгтэй гэж байгаа юм. Бодож байгаа.

Түвшин бол яг үзсэн байх. Би түвшнийг бол хасаад ороод ирээрэй гэсэн шүү дээ. Тэгээд би түвшнийг яагаад одоо 3,6-г хасна гэж мэдэгдэл хийснийг сайн ойлгоогүй. Ер нь бол би хасаад ороод ирээрэй л гэсэн шүү дээ. Түвшин 306 тэрбумыг Түвшин хасаж орж ирсэн. Ажлын хэсэг дээр нөгөөдөх нь 92-ыг оруулаад ажлын хэсэг дээр 92-32 үлдсэн. 32 нь чуулган дээр ороод бас байхгүй. Хасахгүй байгаа байхгүй юу. Өөрсдөө хасахгүй байна шүү дээ. Их Хурал маань 32-ыг хасаж чадахгүй байна шүү дээ. Тэр 18 тэрбумын ваучерыг хүртэл хасаж чадахгүй байна шүү дээ. Тийм учраас би бас энэ хориг ингэж тавигдсанаар бол одоо хасах нөхцөл бүрдэх байх гэж бодож байгаа юм. 18 тэрбумыг хасаж чадахгүй байгаа улс одоо бол харин хасах байх гэж. Тийм учраас ингээд орж ирэхээр бол бид нар нэлээн үзэх хэрэгтэй. Би зүгээр тэр 3,6-г бол үзсэн юм. Одоо энэ Түвшин өөрөө ч мэдэж байгаа байх. 1,4 нь цалин тэтгэвэр тэтгэмж, тэр цэргийн нэмэгдэл гээд энэ Ганбаатарын хэлээд байгаа юм. Энэ бол бүр хүчний байгууллагынх бол 400 гаруй болчихсон байгаа байхгүй юу. Тэрбум. Хуулиараа нэмэгдэж байгаа юм шүү. Би энэ жилийн нэмэгдэж байгааг хэлж байгаа юм. Ингээд 1 тэрбум 400, 500 болчихсон. Цаана нь нөгөө нэг бүсийн хөгжлийг дэмжих зам дэд бүтэц нь 1,4 ингээд 3 тэрбум нь бол зөвхөн энэ 2 шүү дээ. Зөвхөн энэ 2. Цалин тэтгэврийн нэмэгдэл, дээр нь нөгөө бүсийн хөгжлийг дэмжих зам гүүр, дэд бүтэц байхгүй юу. Цаана нь 600 л байгаа юм. Тэр 600 дотор бол тэр 3 хурал гээд байгаа юм. Монгол Улсыг дэмжих, гадаадад сурталчлах билүү 1 тийм зардлууд байгаа юм. Тэгээд тэр ваучер гэдэг ч юм уу иймэрхүү байгаа. Тэгэхээр ингээд ороод яг ингээд хасахад бол Сангийн яамтайгаа нэлээн сайн ярьж байж ерөнхийдөө бол миний бодол юу байсан гэвэл бүтцийн өөрчлөлт хийж хасахаас өөр их төвөгтэй юм байна гэж ингэж харсан. Алтанхуяг гишүүний хэлээд байгаа үнэн. Үнэхээр хаана орон тоо нэмэгдчихэв. Хаана үр ашиггүй бүтцийг бий болгочхов гэдгийг л бид нар уг нь олж хасаж чаддаг бол хамгийн сайн юм байгаа юм л даа. Тэр агуулгаар нь бол Их Хурал бол бас тийм чиглэл өгсөн байсан. Одоо бол ямар ч гэлээ гэсэн тодорхой хэмжээгээр хасалтууд бол ингээд хийгдээд явах байх. Хийгдэх ёстой. Тэгэхдээ бид нар бол энэ дээр нэлээн Сангийн яам, салбарын яамдтайгаа уялдаатай ажиллаж, яг тэр зөв төсвөө захираад зарцуулаад явсан нь биш, үрэлгэн байсан, тоогоо нэмсэн, ажилчдын тоо нь хэт хавтгайрсан, олширсон. Ерөнхийдөө ингээд харахад байна шүү дээ цалин 2020 оноос хойш ингээд харахад 3 дахин, одоо 7 их наяд болчихсон байгаа байхгүй юу. 7 их наяд болчихсон байгаа.

Тэгэхээр энэ чинь цаанаа юу харагдаж байна вэ гэвэл үрэлгэн орон тоонууд нэмэгдсэн гэсэн үг байхгүй юу. Бас энэ тэрийг бид нар нэлээн анхааралтай харахгүй бол бас зарим нэг салбарын асуудалд доголдол үүсэхгүйгээр ингэж шийдэх ёстой. Тэгэхдээ ер нь гишүүдэд маань цаашдаа нэг анхаарах ёстой юм бол энэ салбаруудын хууль орж ирэхэд янз бүрийн нэмэгдлүүдийг ер нь хязгаарлахгүй бол болохгүй юм байна лээ шүү. Зөвхөн тэр нэмэгдэл энэ жилийн тэр 3,6 их наядын 400 тэрбум нь шүү. Зөвхөн тэр нэмэгдэл. Тэгээд цалин тэтгэвэр бол их хэмжээгээр өссөн. Энэ бол нэлээн том өндөр хувийг бол эзэлж байгаа. 7,3 их наяд байх шиг байна лээ. Тэгээд ингээд хэдүүлээ энэ Ерөнхийлөгчийн хориг дээр ажиллах хугацаанд бол бас нэлээн үр бүтээлтэй ажиллаад ингээд хасах ёстой.

Хамгийн гол хоригийн үр дүн бол юу вэ. Дахиж нэмж чадахгүй болж байгаа байхгүй юу. Мань мэт нь хэлээд тоохгүй байсан бол одоо өнөөдөр төрийн тэргүүн хэлэхээр нэг юм хүлээж авч байгаа байхгүй юу. Ингээд цаашдаа яах вэ. Цаашдаа бол харин нэмэхээ болино. Энэ байна шүү дээ. 11 онд байсан төсөв өнөөдөр 2, 3 дахин өсчихсөн байхгүй юу. Үгүй ээ, би чуулганы эхэнд хэлсэн шүү дээ. Ингээд

өсчихсөн шүү. Дан ганц нүүрснээс хамаарч байна шүү. Нүүрсний чинь үнэ унавал хэрэглээ нь буурвал яах юм бэ гэж би хэлж л байсан шүү дээ. Тэгэхэд урдаас инээх битгий уурлах ч битгий хэл бүгд л дуугүй л байсан шүү дээ. 2 дугаар хэлэлцүүлгээс хойш л бүгд ухаараад эхэлсэн. Сайн байна. Одоо харин яг энэ хоригийг хүлээж авснаар хамгийн сайн ач холбогдол бол дахиж ингэж төсөв 2, 3 жилийн дотор 2, 3 дахин нэмэгддэг энэ зүйл зогсох байх гэж би найдаж байгаа юм.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль, тогтоомжид бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах санал хураалт явуулна. Санал хураалтыг бол хоригийг хүлээж авахад 2/3-оор дэмжиж байж хүлээж авдаг. 66 хувийн саналаар. Энийг та бүхэн анхаараарай.

Ингээд Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 19 гишүүн санал хураалтад оролцож, 16 гишүүн дэмжиж, 84,2 хувиар Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авч байна. Хүлээж авахыг дэмжсэн байна. Дэмжсэн байна. Тэр санал нь буруу гарсан гишүүд протоколд тэмдэглүүлчихсэн нь дээр. Энэ бас нэлээн чухал асуудал учир. Хэн хэн байна. Батбаяр, Алтанхуяг ингээд болоо юу. Та 2 микрофондоо хэлчих. Батбаяр гишүүний микрофоныг өгье. Протокол тэмдэглэчихье.

Д.Батбаяр: Сая санал хураалт хийхэд миний төхөөрөмж гацчихлаа. Тэгээд би энэ Ерөнхийлөгчийн хоригийг дэмжиж байгаа учраас протоколд дэмжсэнээр тэмдэглэж өгнө үү.

Ц.Даваасүрэн: Алтанхуяг гишүүн.

Н.Алтанхуяг: Минийх төхөөрөмж гайгүй байсан байх. Миний хуруу гацчихлаа. Тэгээд дэмжиж өгсөн.

Ц.Даваасүрэн: Нас ахиад байгаа юм биш биз. Ойлголоо. Ингээд энэ 2 гишүүнийг протоколд тэмдэглэж авъя.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Аубакир нэгдсэн хуралдаанд танилцуулъя.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг хэлэлцэж дууслаа. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

12.53 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ